

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 19/

2024 оны 11 дүгээр сарын 21

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратегийн зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.4), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3, 7.2.4), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 5.2, 7.5)							
Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна.							
1.1	Арга хэмжээ 1.1 "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд нэмэлт хөгжүүлэлт хийх	Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктai хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: төсөл	Систем бүрэн нэвтрүүлсэн эсэх	1	1	Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэн танилт нэвтрэлтийн ДАН системээр дамжуулан "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд нэвтэрч визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах болон гадаадын иргэнийг бүртгэх үйлчилгээг 2023 оны 12 дугаар 11-ний өдрөөс бүрэн ажиллагаанд оруулсан. Мөн виз, оршин суух үнэмлэх хэвлэлтийг системээс хийх, оршин суух үнэмлэх хүргэлт, иргэн, аж ахуйн нэгж хүсэлтээ цахимаар цуцлах, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрууд системд нэвтэрч хүсэлт илгээх болон хяналтын улсын байцаагчид системд нэвтэрч зөрчил шалган шийдвэрлэсэн дүгнэлтийг оруулах модулийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрүүдэд тус тус шинээр хөгжүүлсэн.	90

						Уригчтай 54 ангиллын визийг цахимаар олгох хөгжүүлэлтийг 09 дүгээр сарын 10-ны өдөр, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгах болон хасалт үйлчилгээг 11 дүгээр сарын 04-ний өдрөөс системд хийж, тайлант хугацаанд нийт 619 удаагийн засвар шинэчлэлтийг хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, мэдээлэл шинэчлэх, зөвшөөрлийн хугацаа сунгах, хүчингүй болгох, зөрчил, саатуулалт, гарах сануулга, албан шаардлага, гарахыг түдгэлзүүлэх болон албадан гаргалтын бүртгэл, хяналт үйлчилгээний хөгжүүлэлтийг хийж, 10 дугаар сарын 31-ний өдрөөс тестийн системд шалгаж байна. Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт"-ийн хүрээнд нэмэлт хөгжүүлэлтийг хийж, байгууллагаас үзүүлж буй бүх төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна. Төслийн хүрээнд хэрэглэгчийн шаардлага, эхлэлийн тайлан, нарийвчилсан дизайны тайлан, хөгжүүлэлтийн бета хувилбар, туршилтын хувилбарын тайланг хүлээн авч, саналыг төслийн нэгжид хүргүүлсэн. Гэрээний дагуу 12 дугаар сард багтаан бүх үйлчилгээг бүрэн цахимжуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр системийн хөгжүүлэлт хийгдэж байна.	
1.2	Арга хэмжээ 1.2 Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-тай холбох	Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран хэрэгжүүлж буй	Мэдээллийн нэгдсэн сантай холбосон эсэх	-	1	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Эрээн, Шанхай, Хөх хотод суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд 04 дүгээр сарын 12-ны өдөр холбож, байгууллагаас гадаадын иргэнд олгосон визийн зөвшөөрлийг системд хандан харах эрх нээж өгсөн. Түүнчлэн 11 дүгээр сарын 18-ны өдөр нэмэлтээр 32 элчин сайдын яам, 10 консулын газар, 4 төлөөлөгчийн	100

		"МОН3936: төсөл				газарт хандах эрх нээж өгснөөр нийт 50 ДТГ-ыг системд холбоод байна.	
1.3	Арга хэмжээ 1.3 Визийн зөвшөөрлийн загварыг шинэчилж, цахим хэлбэрт шилжүүлэх	Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкт хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: төсөл	Загварыг цахим хэлбэрт шилжүүлсэн эсэх	-	1	Цаасан хэлбэрээр олгож байсан визийн зөвшөөрлийг QR код бүхий цахим хэлбэрт шилжүүлж, загварыг байгууллагын даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан. Шинэчилсэн загварыг мөн өдрийн 01/152 дугаар албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлж, "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-д холбогдох хөгжүүлэлтийг хийн 01 дүгээр сарын 30-ны өдрөөс үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.	100
Стратегийн зорилго 2. Төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. (Шинэ сэргэлтийн бодлого-Төрийн бүтээмжийн сэргэлт 6.1), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 5.3.2, 5.3.4), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.5.1), (Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө 3.1.1), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний 5.2)							
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.							
1.4	Баримт бичгийн хуурмаглалыг таних, судлах чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагч томилох, мэдээллийн систем хөгжүүлэх	-	Хариуцах албан хаагч/мэдээллийн систем	-	1/1	Баримт бичгийн хуурмаглалыг таних тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр хамтарсан төсөл хэрэгжүүлэх хүсэлтийг төслийн санал, мэдээллийн системийн хэрэглэгчийн шаардлага, тоног төхөөрөмжийн судалгааны хамт Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад 05 дугаар сарын 09-ний өдөр, Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчинх сайдын яаманд 05 дугаар сарын 14-ний өдөр тус тус цахимаар хүргүүлээд байна. Баримт бичгийн хуурмаглалыг таних, судлах чиг үүргийг Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагч болон байцаагч, боомт, орон нутаг дахь нэгжид нэгжийн дарга, хяналтын улсын ахлах байцаагч болон байцаагч нар хэрэгжүүлж ажиллахаар албан тушаалын тодорхойлолтод тусгасан болно.	70
1.5	Виз мэдүүлгийн цахим системийн	Урсгал зардал	Паспортын MRZ унших нэмэлт	-	1	Системийн хөгжүүлэлтийг хийж 09-дүгээр сарын 30-ны өдөр тестийн горим шилжүүлэн 10 дугаар сарын 10-ны өдөр үйл ажиллагаанд нэвтрүүлэв.	100

	(e-form.mn) нэмэлт хөгжүүлэлт хийх		хөгжүүлэлт хийгдсэн эсэх				
1.6	Объектын судалгааны программ хангамжийн нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Түүвэрлэлт, хэрэглэгчийн эрхийн тохиргооны шинэчлэлт хийгдсэн эсэх	-	1	Объектын судалгааны программд түүвэрлэлт хийх, хэрэглэгчийн эрхийн тохиргоог шинэчлэх хөгжүүлэлтийг 04 дүгээр сарын 05-ны өдөр хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Мөн тус системд нэмэлтээр засварлах шаардлагатай 4 бүлгийн 12 өөрчлөлтийг 04 дугаар сарын 30-ны өдөр хийж гүйцэтгэн бүрэн ажиллагаанд орууллаа.	100
1.7	Цахим архивын программын нэмэлт хөгжүүлэлт хийх	Урсгал зардал	Интернэт орчинд ажиллах хөгжүүлэлт хийгдсэн эсэх	-	1	Цахим архивын программыг 02 дугаар сарын 05-ны өдөр дотоод сүлжээнээс интернэт орчинд шилжүүлж, шаардлагатай бүх өгөгдлийг байршуулан хандах тохиргоог хийсэн. Боомт, орон нутаг дахь газрын инженерүүдэд программын холбогдох хаягийг 02 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлж, зааварчилгаа өгч ажиллалаа. 09 дүгээр сарын 17-ны өдөр системийг дахин шинэчлэн нэмэлт хөгжүүлэлт хийж серверийг Үндэсний дата төв УТҮГ дахь төрийн мэдээллийн Mcloud системээс байгууллагад нүүлгэн шилжүүлэлт хийв.	100
1.8	Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны тоон мэдээллийг хянах самбар (dashboard)-ын программ хангамжийг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх	Урсгал зардал	Программ хангамжийг хөгжүүлсэн эсэх	-	1	Эдийн засаг хөгжлийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "МОН3936: Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн бүрэлдэхүүн хэсэг ЗҮ-03: "Гадаадын иргэний мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэлт"-ийн хүрээнд 6 төрлийн үйлчилгээний дэлгэрэнгүй тоон мэдээллийг харуулах самбар (dashboard)-ыг тухайн систем дээр хөгжүүлж, 03 дугаар сарын 07-ны өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд 12 дугаар сарын 10-ны өдөр гүйцэтгэгч байгууллагатай хийсэн гэрээний хугацаа дуусах тул бүх үйлчилгээний статистик мэдээллийг харуулах хөгжүүлэлтийг энэхүү хугацаанд хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.	100
1.9	Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, үйлчилгээг өргөжүүлэх	Орон нутгийн төсөв	Зохион байгуулалтын ажлын хувь	1	100	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн цаг, зардлыг хэмнэх, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор оршин суух үнэмлэх хэвлэх, олгох үйлчилгээг 02 дугаар сарын 07-ны өдрөөс Чингэлтэй дүүргийн Улсын	70

						бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээний төвд шилжүүлэв. KGB хүргэлтийн үйлчилгээг "Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан" системд нэвтрүүлэн оршин суух үнэмлэх хүргэлтийг зохион байгуулж байна. Оршин суух үнэмлэх хэвлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэвлэх үйл ажиллагааг хялбаршуулах хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газраас зарласан ДГАЗҮСЗДТГ/20240102013 дугаартай тендер шалгаруулалтаар оршин суух үнэмлэх хэвлэх принтер 1 ширхэг, өөрөө хэвлэгч киоск машин 1 ширхгийг тус тус худалдан авч Гадаадын иргэний виз, бүртгэлийн мэдээллийн сангаас хэвлэх үйлчилгээг хийх сервисийн хөгжүүлэлтийг хийж 09 дүгээр сарын 30-ны өдөр бэлэн болгосон бөгөөд 01/09-20 дугаартай гэрээг Ньюкомпас ХХК-тай байгуулан системийн хөгжүүлэлтийг хийж тестийн горимд шилжүүлээд байна. Тайлант хугацаанд нийт 63159 оршин суух үнэмлэх хэвлэгдсэн байна.	
1.10	Газрын даргын тушаалын бүртгэлийн програм хангамж хийх.	Урсгал зардал	Программ хангамж хийгдсэн эсэх	-	1	Захиргаа удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Очгэрэлийн ирүүлсэн саналын дагуу программын хөгжүүлэлтийг хийж 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд тайлант хугацаанд 788 тушаалыг системд байршуулсан байна.	100
1.11	Бусад	Урсгал зардал	Программ хангамжийг хөгжүүлсэн эсэх	-	1	Цахим ситемд Wechat төлбөрийн систем шинээр оруулж, К7, К6 ангилалуудад нэмэлт өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэсэн. К6 визийн support document хэсэгт Виз, тийз хавсаргах талбар default-оор харуулах, маягт 6 хэсэгт 15 асуултыг нэмж оруулан админ хэсгийн тохиргоонуудыг хийсэн. К7 ангилалд админ хэсгийн тохиргоо болон насны хязгаар, Supporting Documents заавал бөглөгдөх 4 талбар, паспортын хүчинтэй хугацааны шалгуур, нэгдсэн статистик тайлан, улс, төлөв, ангилалаар шүүх зэрэг нэмэлт хөгжүүлэлийг хийсэн. Мөн	100

					Гадаадын иргэний виз бүртгэлийн нэгдсэн ISF системтэй мэдээлэл харилцан солилцох, шийдвэр гаргалтыг нэг системээс хийх боломжийг бүрдүүлэхээр хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2025 оны 1 дүгээр сард багтаан дуусгахаар ажиллаж байна. -Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Мальдав Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигч 30 хүртэлх хоногийн визгүй зорчих болсонтой холбоотой Мальдив улсыг визгүй зорчих улсын жагсаалтад оруулж "Жагсаалт шинэчлэн батлах тухай" Гадаад харилцааны сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09/А/53 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Монгол Улсын цахим виз олгох жагсаалт"-д "100.Бүгд Найрамдах Индонез Улс нэмсэнийг системд оруулсан. 2 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн Монгол Улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийн нэгдсэн ISM системд гарсан гэмтэлтэй холбоотойгоор хуучин мэдээллийг харах (2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртлэх) программ хангамжийг шинээр хийж 03 дугаар сарын 27-ны өдрөөс ажиллагаанд оруулав мөн eimmigration.mn систем дээр албандан гаргасан иргэд, хориг, тусгай тэмдэглэлтэй иргэдийн мэдээллийг шүүж харах нэмэлт хөгжүүлэлтийг хийж ажиллагаанд оруулав. Зөрчил шалган шийдвэрлэх газарт иргэн, хуулийн этгээдийн торгуулийн бүртгэлийн системийг шинээр хийж 04 дүгээр сарын 02-нд иргэн, 04 дүгээр сарын 29-ны өдөр Хуулийн этгээдийн бүртгэлийн хэсгийг ажиллагаанд оруулав. 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр "Систем Центр" ХХК захирал Монголын зөвлөх инженер Б.Баасандорж "Мэдээллийн аюулгүй байдал"	
--	--	--	--	--	---	--

					сургалт орсон бөгөөд сургалтанд танхимаар 34, цахимаар 70 нийт 104 албан хаагч хамрагдсан. Байгууллагын А байрны Хүний нөөцийн өрөө, санхүү хангалт үйлчилгээний газар, виз зөвшөөрлийн газруудын сүлжээний шинэчлэлт, засварыг хийж, компьютер, свич, рүтер тоног төхөөрөмжийг сольсон. Б байрны хяналт шинжилгээ, үнэлгээ, аудитийн хэлтэс, зөрчил шалган шийдвэрлэх газруудын сүлжээний шинэчлэлт хийж интернет болон дотоод сүлжээ татаж тоног төхөөрөмжийг сольж сайжруулж техник холболтыг хийж гүйцэтгэсэн. Гадаадын иргэний бүртгэлийн дугаарыг хил хамгааллахын гэрэгэ системтэй 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн холбосоноор гадаадын иргэний бүртгэлийн дугаар хил нэвтрэх үед шууд үүсч эхэлсэн. 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар мэдээллийн санд нийт 741,887 гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгосон байна. 07 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд орон нутаг дахь газрын мэдээллийн технологийн мэргэжилтэнүүдийн сургалтыг зохион байгуулж 5 албан хаагчийг хамруулаад байна.	
Үнэлгээ: 93 хувь						

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин	
			Хүрсэн түвшин (биелэлт)	Үнэлгээ
	1	2	5	7
1.	Арга хэмжээ 1. Мэдээлэл технологийн чиглэлээр сертификаттай хамрагдсан байх сургалтад	сертификат авсан эсэх	Удирдлагын академиас зохион байгуулсан “Цахим засаглалын төлөв, цаашдын чиг хандлага, кибер аюулгүй байдал” 16 цагийн сертификаттай сургалтад 05 дугаар сарын 16,17 өдрүүдэд хамрагдав. (үнэмлэх №24/0787 бүртгэлийн №21657)	100

2.	Арга хэмжээ 2. Монгол хэл бичиг, англи хэлний мэдлэг чадвар дээшлүүлэх сургалтад хамрагдах	Оролцсон сургалт, арга хэмжээний тоо	Удирдлагын академиас зохион байгуулж байгаа Монгол хэл бичгийн анхан, дунд шатны 80 цагийн цахим сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. (гэрчилгээний дугаар: b36to3qcy2, акроквед9q)	50
Үнэлгээ: 75 хувь				

Төлөвлөгөөг үнэлсэн:
ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг



.....
(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч
Н.УУГАНБАЯР
(огноо)

2024.11.21

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)


Нэгжийн дарга

З.ӨНӨРСАЙХАН

(огноо)
2024.12.13

Тайлагнасан:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга

Э.ГАНЗОРИГ

(огноо)

2024.11.21